



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/101/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

А.М.Б. О.О.О. № 0821
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.БЯМБАСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 201.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 6.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
2. Тайлант онд санхүүгийн тайлангийн 178.0 сая төгрөгийн мал амьтадын үлдэгдэл нь мал тооллогын А данснаас зөрүүтэй санхүүгийн тайланд тусгасан;
3. Бараа материалын бүртгэлийг ерөнхий журналд орлого зарлагын дансаар дамжуулахгүй, 16.6 сая төгрөгийг шууд зарлагын гүйлгээ хийсэн.

2125020293

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Дашбалбар сумын ЗДТГ нь 2025 онд 8 зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "бүрэн хангалттай" буюу 91.4 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35	БАРАА МАТЕРИАЛ	254,958,447.35	295,389,197.35
351	Түүхий эд материал	4,573,988.35	4,573,988.35
35110	Тусгай зориулалттай материал	4,573,988.35	4,573,988.35
354	Хангамжийн материал	72,346,059.00	104,386,809.00
35410	Бичиг хэргийн материал	681,260.00	681,260.00
35420	Аж ахуйн материал	28,183,789.00	28,339,789.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	450,000.00
35470	Бусад хангамжийн материал	43,481,010.00	74,915,760.00
35600	Мал амьтад	178,038,400.00	186,428,400.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	254,958,447.35	295,389,197.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,530,824,542.47	7,768,460,917.03
392	Биет хөрөнгө	7,383,009,753.27	7,278,477,546.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,320,720,621.00	4,320,720,621.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-155,813,164.85	-285,414,128.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	258,880,000.00	258,880,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-151,954,666.44	-168,576,000.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	198,900,770.00	172,940,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,836,180.76	-51,018,336.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,352,585.00	58,167,585.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,769,025.00	-42,561,685.48
39209	Зам, гүүрийн байгууламж	3,068,454,849.00	3,179,384,510.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-431,719,246.92	-510,319,551.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	406,413,026.00	386,049,926.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-32,628,813.76	-49,784,992.56
39217	Ном	10,009,000.00	10,009,000.00
393	Биет бус хөрөнгө	80,241,609.20	80,241,609.20
39301	Програм хангамж	1,697,200.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,697,200.00	-
39303	Бусад биет бус хөрөнгө	84,296,000.00	84,296,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-4,054,390.80	-4,054,390.80
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	67,573,180.00	409,741,761.00
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	67,573,180.00	409,741,761.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,530,824,542.47	7,768,460,917.03
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,785,782,989.82	8,063,850,114.38
51	Засгийн газрын хувь оролцоо	7,785,782,989.82	8,063,850,114.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	807,538,535.34	807,538,535.34
51101	Өмч: - төрийн	807,538,535.34	807,538,535.34
512	Хуримтлагдсан үр дүн	6,614,214,872.33	6,892,281,996.89
51210	Өмнөх үеийн үр дүн	4,542,021,247.30	6,614,214,872.33
51220	Тайлант үеийн үр дүн	2,072,193,625.03	278,067,124.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,029,582.15	364,029,582.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,785,782,989.82	8,063,850,114.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,785,782,989.82	8,063,850,114.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,470,806,157.58	3,234,924,413.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,115,257.58	7,260,813.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,793,543.58	5,004,813.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	142,321,714.00	2,256,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,312,690,900.00	3,227,663,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,312,690,900.00	3,227,663,600.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	4,077,730,232.00	569,917,331.90
120	Нийтлэг татварын бус орлого	4,077,730,232.00	569,917,331.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,945,000.00	-
120009	Бусад орлого	-	5,940,089.90
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,016,165,232.00	539,355,242.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,620,000.00	24,622,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,548,536,389.58	3,804,841,744.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,051,427,660.55	2,172,284,636.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,580,757,065.70	1,943,783,207.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,071,550.98	697,796,375.60
210101	Үндсэн цалин	367,955,326.51	407,121,351.44
210102	Нэмэгдэл	200,328,224.47	252,779,841.76
210104	Урамшуулал	31,788,000.00	37,895,182.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,062,718.37	87,862,846.68
210201	Тэтгэврийн даатгал	47,518,007.60	60,530,578.42
210202	Тэтгэмжийн даатгал	5,959,381.25	7,085,345.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,848,971.99	3,478,594.12
210204	Ажилгүйдлийн даатгал	2,077,252.17	3,355,905.35
210205	Эрүүл мэндийн даатгал	10,659,105.36	13,412,423.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,460,056.95	57,900,930.40
210301	Гэрэл, цахилгаан	3,577,021.95	6,111,201.40
210302	Түлш, халаалт	41,923,035.00	48,503,329.00
210303	Цэвэр, бохир ус	960,000.00	3,286,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,326,941.58	55,584,821.00
210401	Бичиг хэрэг	4,624,660.00	5,376,500.00
210402	Тээвэр, шатахуун	36,556,031.58	39,811,375.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,719,450.00	6,233,846.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,246,800.00	4,163,100.00
2105	Нормативт зардал	0.00	350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,115,640.00	25,552,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	2,150,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	160,000.00
210604	Урсгал засвар	11,915,640.00	23,242,600.00
2107	Томилолт, зочны зардал	19,544,500.00	16,596,113.00
210702	Дотоод албан томилолт	19,544,500.00	16,596,113.00

**Дашбалбар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	924,248.00	701,496.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,062.00	65,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,336.00	196,496.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	177,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	781,251,409.82	1,001,438,024.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	603,986,402.85	692,675,157.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	5,050,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	177,015,006.97	303,712,867.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	470,670,594.85	228,501,428.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,358,515.40	13,391,095.98
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,358,515.40	12,051,986.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,339,109.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	136,525,393.67	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,525,393.67	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	319,786,685.78	215,110,332.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	319,786,685.78	215,110,332.96
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,384,645,104.00	1,354,489,984.28
2200	Дотоод эх үүсвэрээр	2,384,645,104.00	1,354,489,984.28
220001	Барилга байгууламж	2,003,894,600.00	0.00
223001	Бусад хөрөнгө	380,750,504.00	1,354,489,984.28
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,436,072,764.55	3,526,774,620.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,112,463,625.03</u>	<u>278,067,124.56</u>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	40,270,000.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,270,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-40,270,000.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,072,193,625.03</u>	<u>278,067,124.56</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,470,806,157.58	3,234,924,413.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,115,257.58	7,260,813.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,793,543.58	5,004,813.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	142,321,714.00	2,256,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,312,690,900.00	3,227,663,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,312,690,900.00	3,227,663,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,471,806,157.58</u>	<u>3,234,924,413.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,890,176,303.58	1,880,434,428.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,419,505,708.73	1,651,932,999.78

**Дашбалбар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,071,550.98	696,856,285.70
210101	Үндсэн цалин	367,955,326.51	406,181,261.54
210102	Нэмэгдэл	200,328,224.47	252,779,841.76
210104	Урамшуулал	31,788,000.00	37,895,182.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,062,718.37	87,862,846.68
210201	Тэтгэврийн даатгал	47,518,007.60	60,530,578.42
210202	Тэтгэмжийн даатгал	5,959,381.25	7,085,345.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,848,971.99	3,478,594.12
210204	Ажилгүйдлийн даатгал	2,077,252.17	3,355,905.35
210205	Эрүүл мэндийн даатгал	10,659,105.36	13,412,423.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,460,056.95	57,900,930.40
210301	Гэрэл, цахилгаан	3,577,021.95	6,111,201.40
210302	Түлш, халаалт	41,923,035.00	48,503,329.00
210303	Цэвэр, бохир ус	960,000.00	3,286,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,873,991.58	38,600,594.00
210401	Бичиг хэрэг	4,624,660.00	5,400,500.00
210402	Тээвэр, шатахуун	36,556,031.58	22,113,148.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,719,450.00	6,497,846.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,793,850.00	4,589,100.00
2105	Нормативт зардал	1,204,500.00	350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,204,500.00	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,334,990.00	27,632,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	7,249,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	160,000.00
210604	Урсгал засвар	21,134,990.00	20,223,600.00
2107	Томилолт, зочны зардал	19,544,500.00	16,596,113.00
210702	Дотоод албан томилолт	19,544,500.00	16,596,113.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	924,248.00	881,496.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,062.00	245,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,336.00	196,496.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	177,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	609,029,152.85	725,252,134.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	608,779,152.85	720,202,134.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	5,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	470,670,594.85	228,501,428.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,358,515.40	13,391,095.98
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,358,515.40	12,051,986.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,339,109.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	136,525,393.67	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,525,393.67	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	319,786,685.78	215,110,332.96

**Дашбалбар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	319,786,685.78	215,110,332.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>1,890,176,303.58</u>	<u>1,880,434,428.72</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>581,629,854.00</u>	<u>1,354,489,984.28</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	581,629,854.00	1,354,489,984.28
2200	Дотоод эх үүсвэрээр	581,629,854.00	1,354,489,984.28
223001	Бусад хөрөнгө	353,750,504.00	1,354,489,984.28
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	227,879,350.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	581,629,854.00	1,354,489,984.28
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-581,629,854.00</u>	<u>-1,354,489,984.28</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	807,538,535.34	364,029,582.15	4,546,075,638.10	5,717,643,755.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-4,054,390.80	-4,054,390.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	807,538,535.34	364,029,582.15	4,542,021,247.30	5,713,589,364.79
Тайлант үеийн үр дүн	-	-	2,072,193,625.03	2,072,193,625.03
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	807,538,535.34	364,029,582.15	6,614,214,872.33	7,785,782,989.82
Тайлант үеийн үр дүн	-	-	278,067,124.56	278,067,124.56
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	807,538,535.34	364,029,582.15	6,892,281,996.89	8,063,850,114.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,274,785,100.00	3,176,800,800.00	1,097,984,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	827,644,900.00	696,856,285.70	130,788,614.30
210101	Үндсэн цалин	442,578,600.00	406,181,261.54	36,397,338.46
210102	Нэмэгдэл	346,434,100.00	252,779,841.76	93,654,258.24
210104	Урамшуулал	38,632,200.00	37,895,182.40	737,017.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,080,500.00	87,862,846.68	16,217,653.32
210201	Тэтгэврийн даатгал	70,774,800.00	60,530,578.42	10,244,221.58
210202	Тэтгэмжийн даатгал	8,326,400.00	7,085,345.21	1,241,054.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,163,200.00	3,478,594.12	684,605.88
210204	Ажилгүйдлийн даатгал	4,163,200.00	3,355,905.35	807,294.65
210205	Эрүүл мэндийн даатгал	16,652,900.00	13,412,423.58	3,240,476.42
2104	Хангамж, бараа материалын зардал	39,198,900.00	32,835,894.00	6,363,006.00
210401	Бичиг хэрэг	4,176,500.00	3,944,500.00	232,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,272,700.00	17,954,448.00	3,318,252.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,389,000.00	6,347,846.00	1,041,154.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	475,900.00	-	475,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,884,800.00	4,589,100.00	1,295,700.00

**Дашбалбар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2105	Нормативд зардал	1,401,400.00	350,000.00	1,051,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,401,400.00	350,000.00	1,051,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,020,100.00	27,632,600.00	1,387,500.00
210601	Багаж, техник хэрэгсэл	4,624,900.00	7,249,000.00	(2,624,100.00)
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	532,300.00	160,000.00	372,300.00
210604	Урсгал засвар	23,862,900.00	20,223,600.00	3,639,300.00
2107	Томилолт, зочны зардал	26,380,000.00	15,640,000.00	10,740,000.00
210702	Дотоод албан томилолт	26,380,000.00	15,640,000.00	10,740,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	7,706,000.00	881,496.00	6,824,504.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	3,847,300.00	245,000.00	3,602,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	-	1,296,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,600.00	-	473,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	363,200.00	196,496.00	166,704.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	156,400.00	-	156,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	896,300.00	440,000.00	456,300.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	673,200.00	-	673,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,401,600.00	57,900,930.40	500,669.60
210301	Гэрэл, цахилгаан	6,611,800.00	6,111,201.40	500,598.60
210302	Түлш, халаалт	48,503,400.00	48,503,329.00	71.00
210303	Цэвэр, бохир ус	3,286,400.00	3,286,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,186,556,700.00	729,696,134.00	456,860,566.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,181,247,800.00	724,646,134.00	456,601,666.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	5,308,900.00	5,050,000.00	258,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,520,000.00	13,391,095.98	3,128,904.02
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,520,000.00	12,051,986.38	2,468,013.62
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,339,109.60	660,890.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,977,875,000.00	1,323,643,184.28	654,231,815.72
223001	Бусад хөрөнгө	1,977,875,000.00	1,323,643,184.28	654,231,815.72
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		190,110,332.96	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,274,785,100.00	3,176,800,800.00	1,097,984,300.00
122005	Улсын төсвөөс санхүүжих	4,269,288,700.00	3,176,800,800.00	1,092,487,900.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,496,400.00	-	5,496,400.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,496,400.00	-	5,496,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,260,813.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,260,813.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,260,813.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,764,700.00

210401	Бичиг хэрэг	1,456,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,158,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00
2107	Томилолт, зочны зардал	956,113.00
210701	Гадаад албан томилолт	
210702	Дотоод албан томилолт	956,113.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,260,813.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,260,813.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,004,813.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,256,000.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Завсрын аудитаар нийт 53.5 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэж завсрын аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 23.5 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.
- Бараа материал дансанд 29.8 сая төгрөгийн бараа материалын ангиллыг өөрчилж залруулав. Энэ нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул залруулав.
- Цалин нийт зардал, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангийн тайлагнасан дүнг 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журмын 4.1.3-т “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх” 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх” гэсэнтэй нийцэхгүй байсныг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 201,343.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 179,464.5 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 201.3 сая төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 184.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, 16.6 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Зардлыг анхан шатны баримттай тулгахад 6,689.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг дээд шатны байгууллагаас баталсан жишиг нормтой тулган хяналт хийгээгүй, зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам, тээвэр хөгжлийн яамны 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д заасныг зөрчсөн тул албан шаардлага өгөв.
2. Тайлант онд санхүүгийн тайланд тайлагнасан 178.0 сая төгрөгийн мал амьтадын үлдэгдэл нь мал тооллогын А данснаас зөрүүтэй, тооллогоор гарсан зөрүүг нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгаагүй санхүүгийн тайланг гаргасан нь УСНББОУС 1 *Санхүүгийн тайлагналын толилуулга*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 2-т "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэнтэй нийцэхгүй байгаа тул албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Бараа материалын бүртгэлийг ерөнхий журналд орлого зарлагын дансаар дамжуулахгүй, 16.6 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэж заасны дагуу бүртгэлийг хөтлөөгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан хийж байх.

2. Хууль, тогтоолын хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: ЗГ-ын 2009 оны 13 дугаар "Сумын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолоор хүн амын тооноос үндэслэн орон тооны хязгаарыг тогтоодог ба 2025 оны байдлаар 3544 хүн амтай /3001-5000/ учир жишиг нормын дагуу 16 хүний орон тоотой байхаар байна. ЗД-ын 2025.01.03-ны өдрийн Б/01 захирамжаар нийт 20 орон тоотой /УТ албан тушаалын ангилал оруулаагүй/ байхаар баталсан байна. Тайлант хугацаанд УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолоор "...багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар буруулах..." арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тогтоолын хэрэгжилтийг хангаж чиг үүргийн давхардлыг арилгаж ажиллах;

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	23,548.0					1	23,548.0				
Бараа материалын ангилал зөрүүтэй бүртгэсэн	1	29,879.5					1	29,879.5				
Цалин, НД, ХХОАТ-ын тайлангийн зөрүү	1	119.1					1	119.1				
Дүн	3	53,546.7					3	53,546.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зардал хэтрүүлсэн	1	6,689.0			1	6,689.0						
Малын тоо толгой А дансанд дахь дүн хоорондоо зөрүүтэй	1	178,038.4			1	178,038.4						

**Дашбалбар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Шатахуун шууд зарлагдсан.	1	16,616.1			1	16,616.1						
Дүн	4	201,343.5			3	201,343.5	1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цахим хуудсанд байршуулаагүй, хугацаа хоцроосон.	1	2,085,054.4			1	2,085,054.4		
УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орон тоо бууруулж ажиллаагүй	1	-					1	-
Нийт дүн	2	2,085,054.4			1	2,085,054.4	1	0.0